



МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ТУШААЛ

2014 оны 07 сарын 21 өдөр

Дугаар 106

Улаанбаатар хот

Үнэт цаасны бүртгэлд
өөрчлөлт оруулах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны 2014 оны 06 сарын 25-ны өдрийн 248 тоот тогтоол, “Монголын хөрөнгийн бирж” Төрийн өмчит хувьцаат компанийн “Үнэт цаасны бүртгэлийн журам”-ын 50.2, 57 дугаар зүйлийг тус тус үндэслэн **ТУШААХ НЬ:**

1. “Түшиг-Уул” хувьцаат компанийн гаргасан нэг бүр нь 100 төгрөгийн нэрлэсэн үнэтэй 434,577 ширхэг хувьцааг нэг бүр нь 10 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 4,345,770 ширхэг энгийн хувьцаанд хувааж, компанийн бүртгэлд өөрчлөлт оруулсугай.
2. Холбогдох мэдээллийн санд өөрчлөлт оруулж, “Үнэт цаасны төлбөр тооцоо төвлөрсөн хадгаламжийн төв” хязгаарлагдмал хариуцлагатай компанийн хадгаламжид өөрчлөлт оруулах мэдэгдэл хүргүүлэхийг Үйл ажиллагааны газар /Б.Тунгалаг/-т үүрэг болгосугай.
3. “Түшиг-Уул” хувьцаат компанийн бүртгэлд өөрчлөлт орсон тухай мэдээллийг олон нийтэд хүргэхийг Зах зээлийн хөгжлийн газар /Ж.Мягмарсүрэн/-т үүрэг болгосугай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН
ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ



Д. АНГАР

2014 оны 07-р сарын 21

**ҮНЭТ ЦААСНЫ ТӨЛБӨР ТООЦОО
ТӨВЛӨРСӨН ХАДГАЛАМЖИЙН ТӨВ ХХК-Д**

**ҮНЭТ ЦААСНЫ ХАДГАЛАМЖИНД ӨӨРЧЛӨЛТ
ОРУУЛАХ МЭДЭГДЭЛ № 386-д**

СЗХ-ны 2014 оны 06 сарын 25-ны өдрийн 248 тоот тогтоол, МХБ-ийн Гүйцэтгэх захирлын 2014 оны 07 сарын 21-ны өдрийн 20 тоот тушаалын дагуу хадгаламжид дараах өөрчлөлт оруулахыг мэдэгдье.

| ҮЗҮҮЛЭЛТ | | БҮРТГЭХ |
|-------------------------------------|-------------------------------|------------------|
| Үнэт цаасны нэр: | | “Түшиг-Уул” ХК |
| Үнэт цаасны төрөл: | | Хувьцаа |
| Үнэт цаасны хэлбэр: | | Энгийн |
| Нийт хувьцааны тоо ширхэг: | Одоогийн бүртгэл | 434,577 |
| | Бүртгэлд орох өөрчлөлт | 4,345,770 |
| Хувьцааны нэрлэсэн үнэ: /төгрөг/ | Одоогийн бүртгэл | 100 |
| | Бүртгэлд орох өөрчлөлт | 10 |

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН
ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
ГАЗРЫН ДАРГА



Д. АНГАР

Б. ТУНГАЛАГ